



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 26/02

Улаангом сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх заалт, 59.9, 59.10 дугаар заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Увс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэн ТОГТООХ нь:

Нэг. “Увс Хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 09:00 цагт Увс аймаг, Улаангом сум, 5-р баг, “Увс Хүнс” ХК-ийн байр, Захирлын өрөөнд зарлан хуралдуулсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр оруулсугай.

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн томилгоог батлах

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сонингоор болон Монголын хөрөнгийн

биржийн цахим хуудсаар олон нийтэд зарлан мэдээлнэ. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

Тав. Ээлжит хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалтыг 02 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувь нийлүүлэгчдэд хуралтай холбоотой мэдээ, мэдээлэл өгөх, материал, бичиг баримттай танилцуулах ажиллагаа нь ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “Увс Хүнс” ХК-ийн байранд явагдах бөгөөд тус ажиллагааг эрхлэн, зохион байгуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (О.Оюунхүү)-д даалгасугай.

Долоо. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдээс, харьяалагдах брокер дилерийн компаниар дамжуулан Санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр тасалбар болгосугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар “Увс Хүнс” ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Мөнхнаран, тооллогын комиссын даргаар Ж.Бааст, гишүүнээр Д.Буянхишиг нарыг тус тус томилсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.МӨНХНАРАН



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 26/03

Улаангом сум

Тооллогын комиссыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалтыг үндэслэн
Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ж.Бааст, гишүүнээр Д.Буянхишиг нарыг тус тус томилсугай.
2. Тооллогын комиссын дарга Ж.Бааст, гишүүн Д.Буянхишиг нарт Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэн ажиллахыг даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.МӨНХНАРАН